

ПОРТ АРТУРЫН ХЭРЭГ

ХЭРЭЭД ЖАМСРАНГИЙН УРАНГУА¹

Товч агуулга: XX зууны Монголын түүхийн хар толбо болсон үзэгдэл болох хэлмэгдүүлэлтэд зөвхөн монголчууд өртөөд зогсохгүй тус улсад амьдарч, ажиллаж байсан гадаадын иргэд мөн өртсөн байдаг. 1947-1949 онуудад тус улсад энгийнээр оршин сууж байсан нэр бүхий 80 хятад иргэн Гоминданы тагнуулын байгууллагын алан хядах, галдан шатаах, хорлон сүйтгэх салбар хэсэгт элсэн орж, хот хөдөөд зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна хэмээн үзэж, тэдгээр хүмүүсийг 3 ээлжээр дайчлан байцаан хорьж, хэрэг үүсгэн шийтгэсэн байна. Эл хэрэгт “Порт Артурын” гэх нэр өгчээ.

БНМАУ-д 1952 онд маршал Х.Чойбалсан, ЗХУ-д 1953 онд И.В.Сталин нас барснаар нэг хүний дарангуйллын дэглэм сарниж, улс төрийн уур амьсгал харьцангуй зөөлрөн хамтын удирдлагын зарчим сэргэж эхэлсэн тэр үед МАХН-ын удирдлагын зүгээс 1930-1940-өөд онд явагдсан баривчилгаа, залхаан цээрлүүлэлтийн хор уршгийг арилгах асуудлыг хөндөж зарим нэгэн бүлэг хэргийг хянан үзэх санаачилга гаргаж эхэлжээ. Дотоод явдлын яам Намаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Дотоод яамны үйл ажиллагаанд гарч байсан алдаа завхралыг илрүүлэх ажлын хүрээнд Порт Артурын хэргийг дахин авч үзээд, уул хэрэг зохиомол хэрэг байсан байна гэдгийг тогтоожээ.

Улмаар МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1955 оны тавдугаар сарын 18-ны өдрийн хурлаар “Порт Артурын хэрэг” –ийг шалгасан комиссын илтгэлийг хэлэлцээд түүнд холбогдож шийтгэгдсэн хүмүүсийг суллан цагаатгаад мөн мөрдөн байцаалтад хууль бус арга хэрэглэхийг зөвшөөрсөн өмнөх үеийн шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээ авчээ.

Энэхүү өгүүлэлд XX зууны 40-өөд оны төгсгөл үед буюу Дундад иргэн улсад иргэний дайн төгсгөл болж Гоминданыхны засаглал нуран унаж, коммунистууд засгийн эрхэнд гарсан тэрхүү үед Бүгд Найрамдах Монгол Ард улсад “Гоминданы тагнуулын хэрэг” хэмээх зүйлийг ДЯЯ-ны гуравдугаар хэлтэс үүсгэж, өргөн ажиллагаа явуулсан талаар болон түүнийг хожим нь хэрхэн авч үзсэн талаар дэлгэн тавина. Порт Артурын гэх хэрэг ямар зорилготой байсан хийгээд түүнийг захиалагч нь хэн, ямар хүчин байсныг бид өнөөдөр бүрэн мэдэх боломжгүй, гагцхүү таамаг дэвшүүлэх төдий байна. Учир нь Тусгай Архивын бүх материалыг үзэх эрх бидэнд байхгүй. Гэвч эл хэрэг цагаатгагдсан хэрэг учир зарим баримтуудыг үзэх боломжтой байна.

Ингээд ДЯЯ-аас мөрдөн мөшгөх хэрэг үүсгэн олон арван хятад иргэдийг дайчлан баривчлан байцааж, улмаар шийтгэсэн явдал хэрхэн явагдсан хийгээд хожим нь эл хэргийг зохиомол хэрэг хэмээн үзэж, хэрэгт холбогдон Эрүүгийн байцаан шийтгэх

¹ МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор.Улаанбаатар-15160, Монгол Улс. Цахим хаяг: urangua@num.edu.mn, <https://orcid.org/0000-0002-9517-3742>

хуулиар шийтгэгдсэн хүмүүсийг хэрхэн цагаатгасан талаар Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив болон Үндэсний Төв Архивд хадгалагдаж буй баримтууд дээр тулгуурлан дэлгэн тавьж, түүхэн үйл явдлын талаар үнэн бодит мэдээлэл хүмүүст өгөх нь зүйтэй хэмээн судлаач хүний хувьд үзэн энэхүү өгүүллийг бичсэн болно. Энэ хэргийг удаа дараа, тухайлбал: 1955-1956, 1994-2001 онуудад нэхэн сөхөн авч үзэж байсан нь хэрэг хуучирдаггүйн нэгэн илрэл бөгөөд хэргийн учиг бүрэн тайлагдтал энэ үргэлжлэх буй амуй.

Түлхүүр үгс: монгол, гоминдан, тагнуул, дайчилгаа, хэлмэгдүүлэлт, цагаатгал, зохиомол хэрэг

Өмнөтгөл

Монгол улсад ардын засаг тогтсоны дараахан Саж ламын хэрэг, 1922 оны намар Ардын засгийн газрын анхны Ерөнхий сайд Догсомын Бодоо нарын 14 хүнийг Шар хаданд цаазлан хороосноор эхэлсэн юм². Үүнээс хойш бидний өгүүлэн буй үе хүртэл 10-аад улс төрийн хэргээр олон мянган хүнийг амь нас, эд хөрөнгөөр нь хохироосон байдаг³. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн оргил үе бол 1937-1940 он бөгөөд Монгол улсын 25 мянга орчим хүн хэлмэгдсэн юм. Үүнээс хойш ч хэлмэгдүүлэлт ямар нэгэн хэмжээгээр гарсаар байсан бөгөөд төр, засгаас тэдгээр хэргүүдийг дахин авч хэлэлцэж цагаатгах ажлуудыг 1953 оноос хойш хийсээр ирсэн байна. Ялангуяа 1990 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс байгуулж, улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөн олговор олгох талаар нэлээд ажлыг хэрэгжүүлсэн байна.

Хэлмэгдүүлэлтэд зөвхөн монголчууд төдийгүй тус оронд оршин сууж байсан хятадууд хэлмэгдсэн нэгэн хэрэг бол 1947-1949 онуудад өрнөсөн “Порт Артурын хэрэг” гэгч юм. Үүнд, Гоминданы Хятадын тагнуулын байгууллагад элсэгдэн Монголын эсрэг тагнан турших, хорлон сүйтгэх, нам төрийн удирдагч нарын амь насанд халдах үйл ажиллагаа явагдаж байна гэсэн цуу яриа дэгдээж, түүний дагуу ДЯЯ-ны гуравдугаар хэлтсээс ажиллагаа явуулж, хятадуудын эсрэг хэрэг өдөөн, баривчилгаа дайчилгаа хийж, 80 хятад иргэдийг эл хэрэгт хамааруулан шийтгэсэн хэрэг үйлджээ. Тэдгээр хятад иргэд нь Монголын иргэншил аваагүй*, Хятадын харьяатууд байв.

Гоминданы Хятад нь 1946 онд БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн билээ. Гэвч Хятадад өрнөж байсан иргэний дайны улмаас Монголд дипломат төлөөлөгчдийн газраа нээгээгүй байв. 1947-1948 он гэхэд өмнөд хөршид өрнөж байсан иргэний дайнд Зөвлөлтийн дэмжлэг авч байсан коммунистууд ялалт байгуулах, харин гоминданууд ялагдал хүлээх нь бараг ойлгомжтой болсон үе байв. Ийм үед гоминданыхан Монголд тагнуулын ажиллагаа явуулж байсан гэх нь эргэлзээтэй мэт. Гэвч ямартаа ч “Порт Артурын хэрэг” хэмээн нэрлэгдсэн, хятад

² Монгол улсын Дээд шүүхийн 1997 оны 6 сарын 11-ний өдрийн 236 тоот тогтоолоор Д.Бодоод ногдуулсан хилс хэргийг хэрэгсэхгүй болгон нэр төрийг нь цагаатгасан байна. Лхамсүрэнгийн Бат Очир. Догсомын Бодоо.// Эмхэтгэж, оршил бичиж, хэвлэлд бэлтгэсэн Б.-О. Болд, Б. Туяа, Б. Батболд Улаанбаатар: “Никель Декель» ХХК., 2010 он

³ З.Лонжид, О.Багсайхан, С.Баатар. Хэлмэгдүүлэлт ба цагаатгал: түүх ба баримт. Улаанбаатар, “Битпресс” ХХК.2020, т.11-12

иргэдийг сэжиглэн байцааж, цагдан хорьж, эрүүдэн хэрэг хүлээлгэж, улмаар хатуу ширүүн ял оноосон хэрэг гарчээ. Яагаад “Порт Артурын хэрэг” хэмээн нэрлэсэн нь ч ойлгомжгүй байна.

Тухайн үед Хятадын Шар тэнгист Порт Артур хэмээх хөлддөггүй усан боомт байсан бөгөөд Азийн чөлөөлөх дайны үед Зөвлөлтийн цэргүүд 1945 оны 8 сарын 22-нд тэндээс япончуудыг зайлуулан, улмаар Зөвлөлт болон Хятад нь Порт Артурын бүсийг тэнгисийн цэргийн бааз болгон 30 жилийн хугацаанд ашиглах тухай гэрээнд гарын үсэг зурсан байсан ба 30 жилийн дараа Хятадын өмч болох ёстой байсан юм⁴. Хятад иргэдийг хэлмэгдүүлсэн энэхүү зохиомол хэрэгт “Порт Артурын” хэмээн нэрлэсэн учрыг одоогоор тайлж үл чадав. Харин Монголын улс төрийн амьдралд хожмоо зохиомол хэргээр хүмүүсийг хэлмэгдүүлэх болсон явдлыг “Порт Артурын хэргийн нэгэн адил хэмээн” нэрлэн ярих болсон байдаг. Тухайлбал, түүх Л.Жамсран: “Төмөр-Очир, Лоохууз нарын хэрэг гэгч нь нөгөө л “Порт Артур” хэрэг гэгч шүү дээ. Одоо бүх юм айх, сэрдэгдэхээс болоод худал хуурмаг хэлбэртэй болж шударга санал шүүмжлэл байхгүй болжээ” хэмээн хэлж байсан байна⁵.

Эх сурвалж, судалгааны арга зүй

Тус өгүүллийг бичихэд Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архивд хадгалагдаж буй Порт Артурын хэрэг гэгчид хамаарах Мөрдөн байцаалтын хавтаст хэргүүд, мөн тус хэргийн Цагаатгалын баримтууд, Үндэсний Төв Архивд хадгалагдаж буй Дээд шүүхийн тогтоолууд зэрэг анхдагч эх сурвалжууд судалгааны гол хэрэглэгдэхүүн болсон болно. Судалгааны аргазүйн нь түүхэн-систем хандлага ба ретроспектив аргыг хэрэглэсэн. Мөн бичлэгт түүхэн зүйн зарчмыг баримтлан, интерпретацийн аргаар бичсэн болно .

1. Порт Артурын хэрэг өрнөсөн нь

“Порт Артурын хэрэг” хэмээн нэрлэгдсэн Гоминданы тагнан турших, алан хядах эсэргүү байгууллага байна гэсэн хэргийг 6 сарын хугацаанд боловсруулан дайчилгааг 3 ээлж болгон явуулж, мөрдөн байцаалтыг 1948 оны 4 сараас 1949 оны 10 сар хүртэл явуулж дуусгажээ.

Монгол улсад 1940 оны байдлаар 7039 хятад иргэд оршин сууж байсан бөгөөд түүний 4425 нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байв⁶.

Хятад иргэдийн дунд тухайн үеийн Монгол орны эдийн засгийн байдалтай буюу нам засгаас дамын худалдаачид, хувийн үйлдвэр эрхлэгчдийн талаар авч хэрэгжүүлж байсан бодлого шийдвэртэй холбогдуулж шүүмжлэлтэйгээр ярьж байсан яриа өгүүллийн төдий зүйл гарч байжээ⁷. ДЯЯ нь Порт Артурын хэрэг гарахаас өмнө Зөвлөлт, Монголыг буруушаасан, эд таваар ховор, амьдрах аргагүй

⁴ China, Soviet Union: Treaty of Friendship and Alliance // The American Journal of International Law Vol. 40, No. 2, Supplement: Official Documents (Apr., 1946), pp. 51-63

⁵ Нийгмийн ухааны институтэд ажиллаж байсан Дэрдэв гэгч 1966 онд 42 хүний нэрийг хамруулан бичсэн мэдээлэл-матааст үүнийг тэмдэглэжээ. НХШХ-ны баримтын төвд хадгалагдаж буй Л.Жамсрангийн хавтаст хэрэг. Т.9

⁶ Х.Мэндсайхан. Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал (1921-1940). УБ., 2012, тал 50

⁷ Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив. Сан 4. Цагаатгалын хэрэг 8803 (22), тал 130

байна, хятадуудыг мал шиг үзэж, хувийн ажил ба худалдаа хийгчдийг хавчиж байгаа нь Японоос дор байна гэж ярьсан гэсэн шалгаагдаагүй мэдээлэлтэй байсан агаад тийнхүү хэл ярианд 13 хятад хүн холбогдож буйг ч мэдэж байжээ⁸.

1947-1948 онуудад албан ажилгүй хятад иргэдийг албан журмын хөдөлмөрт дайчлах ажиллагаа зохиогдож байв. Энэ байдлыг ашиглан Дотоод яамны III хэлтэс (Төрийн тусгай-маршал болон ерөнхий сайдын аюулгүй байдлыг хангах)-ээс өөрийн мэдээлэгч нараар дамжуулан нэгэн ажиллагаа явуулжээ. Үүнд: гуравдугаар хэлтсийн дарга Ч.Мэнд, тус хэлтсийн ажилтан Н.Рэнцэндоо нар хэргийг гардан боловсруулж, яамны мэдээлэгч Х.Чойбалсангийн байрны уурын зууханд механик ажилтай байсан Б.Дэмбэрэл (Буу гэгч-Ж.У.) гэгчээр дамжуулан маршал Чойбалсангийн байранд ажилтнуудыг ажилд авна гэсэн зарыг тараажээ. Чингэхдээ хятадуудыг маршалын байранд ажилд оруулах оролдлоготой болгуулахын тулд маршалын байранд орон тоо дутуу, ажилчин хэрэгтэй, амьдралаар сайн, албан журмын ажлаас чөлөөлж татвар хөнгөвчилнө гэж таниулжээ. Улмаар хятадуудаас маршалын байранд ажилд орох эрмэлзэл заавал гаргах даалгаврыг мэдээлэгч Буу-гээр дамжуулан хэлүүлснээс үндэслэн Жүн-нөн-гүй* нарын хэсэг хятадууд маршалын байранд ажилд орох яриаг тархааж эхэлсэн байна.

Анх Б.Дэмбэрэлийн танил Самбуу (хятад нэр нь Ли-юу-и)-гийн найз Жан-Сан-Му зах дээр 1947 оны 9 сард түүнтэй тааралдаад: "... миний хамт худалдаа хийдэг Жүн-нөн-гүй албан журмын хөдөлмөрт хөөгдөх гээд байна. Ажил мэдэж байгаарай" гэж захижээ. Дэмбэрэл түүнийг нь мэдээ болгон ДЯЯ-нд бичиж хэлтсийн дарга Ч.Мэндэд өгөхөд тэр орос сургагчтай зөвлөж ирээд Б.Дэмбэрэлийг Х.Чойбалсангийн байранд ажилладаг, манай тэнд усан пийшингийн галч, тогооч, цэцэрлэг усалж, тахиа маллах зэрэг ажлын орон тоонууд байна гэж яриулах даалгаврыг Рэнцэндоогоор дамжуулан өгчээ. Мэдээлэгч Буу гэгч нь хятад, монгол бичиг мэдэхгүй, эд мөнгө, архинд автагдсан этгээд байсан ба гуравдугаар хэлтсийнхний даалгавраар хятад иргэдийн эсрэг тагнуулын ажиллагаа явуулж эхэлжээ.

Мэнд, Рэнцэндоо нар нь хятадууд ажилд орохыг эрмэлзэхийг улам гүнзгийрүүлэн лаборатори агент байсан Минжүүрийг маршалын комендант гэдэг нэрээр тэдгээр хятадуудтай хоёр удаа мэдээлэгч Буу-гийн гэрт уулзуулж анкетыг нь бичиж авах зэргээр маршалын байранд шаварчин, цэцэг услагч, пийшин галлагч зэрэг хүмүүс хэрэгтэй гэж ярьж байсны гадна Минжүүр, Буу нараас дамжуулан сайн тогооч олох шаардлагыг хятад Жүн-нөн-гүй, Жан-сан-муу нарт тавьсан учраас Жан-сан-му нь уг шаардлагыг биелүүлж Хондын амралтын тогооч байсан Юй-жин-байг олж өгч байжээ.

Б.Дэмбэрэл Жүн-нөн-гүйтэй очиж уулзаад Жүн-нөн-гүй өөрөө ажилд орж, тохирох мэргэжлийн хүмүүсийг олж өгч болно гэсэн байсныг үндэслэн ажилд орох хүсэлттэй байсан хятадуудын фото цээж зураг, өргөдөл, анкетыг авч лабораторийн ажилтан Минжүүр гэгчийг маршалын байрны комендант нэрээр Б.Дэмбэрэлийн гэрт хятадуудтай уулзуулж яриулаад, боловсруулах хэрэг нээжээ. Ийм шаардлага ятгалгаар зураг анкетаа өгсөн хятад иргэд нь хожмоо маршалын байранд шургалан орж, түүнийг алахаар бэлтгэж байсанд тооцогдсон байна.

* Хятад хүмүүсийн нэрийн бичлэгийг Архивын баримт дээр тэмдэглэснээр нь бичив-Ж.У.

⁸ ТЕГ ТА, МБХ 15192, тал 8

Түүгээр үл барам Жүн-нөн-гүй болон Жан-сан-муу нарыг Гоминданы тагнуулын байгууллагын Монголд үйл ажиллагаа явуулах хэсгийн удирдагч нар хэмээн үзэж, баривчлан хорьж байцаасан байна. Жүн-нөн-гүй мэдүүлэгтээ: “Улаанбаатар хотын 1 дүгээр хорооны харьяа хятадын 2 дугаар гудамжинд амьдарч, хувийн дэлгүүр ажиллуулдаг. 1925 онд Монгол улсад орж ирсэн, Шаньси мужийн уугуул. 1945 онд Өвөр Монголын Хөх хотод хувийн хэргээр явсан. Тэгэхдээ Гоминданы тагнуулын байгууллагад элссэн. Тухайлбал, буцах замдаа Ху Мин дэх цэргийн тагнуулын газрын даалгавраар БНМАУ-д суурин сууж тагнуулын ажлыг явуулахын хамт маршал Чойбалсанг алах даалгаврыг нэгэн адил авч ирсэн. Энэ тухайгаа Жан-сан-мууд танилцуулсан. Өөрийн даалгаврыг биелүүлэхийн тулд маршалын байрны доторх харуул хамгаалалтын байдал, юу юу байдаг зэргийг сонирхон мэдээд надад хэлэхийг түүнд даалгасан юм”⁹ гэж мэдүүлсэн байна. Жүн-нөн-гүйг алан хядах үйл ажиллагаа явуулах гэж байна гэсэн сэжиглэлээр (1948.4.29) прокурорын зөвшөөрөлтэйгөөр баривчилжээ.

Жүн-нөн-гүй анх дайчлахад түүний хэргийн материал бүрдээгүй байсан байна. Түүний хөрөнгийг хураан авсан актад: алтан бөгж 5, давтмал 4 жин алт (1 ширхэг нь 89 гр.), 700 хятад мөнгөн төгрөг/зоос хэмээн тэмдэглэсэн байна. Ингээд түүнийг 1948 оны 4 дүгээр сарын 29-нөөс мөн оны 6 сарын 4-ны өдрийг хүртэл нийтдээ 53 удаа байцааж, 23 хүний нэр гаргуулж авчээ. Улмаар тэдгээр хүмүүсийг нэг бүрчлэн байцааж, хэрэг үүсгэжээ. Порт Артурын хэргийн эхний ээжийн ажиллагаанд 28 хятад иргэнд тагнуулын болон бусад хэрэг үүсгэжээ. Баривчлагдсан хүмүүсийн эд хөрөнгийг хураан авах ажиллагаа хийжээ.

Хэрэгтний мөрдөн байцаалтын хавтаст хэргийн эхэнд урдаас болон хажуугаас авсан фото цээж зураг, хэрэгтний гарын үсэг, баруун гарын долоовор хурууны хээ (хэрэв тэр хуруу байхгүй бол дараагийн хурууны хээ)-г даруулсан байх аж. Хавтаст хэргийн эхэнд тухайн хүний товч намтар, Монголд хэзээ хэрхэн орж ирсэн, гэр бүл, ам бүлийн тухай мэдээлэл, одоо ямар хаяг дээр амьдардаг болон ямар ажил хөдөлмөр эрхэлж буйг тэмдэглэн бичсэн байна. Дараа нь ямар хэрэгт холбогдсон, түүнийг нь илчлүүлэхийн тулд хийсэн мөрдөн байцаалтын хэргүүдийг бичсэн байх бөгөөд төгсгөлд нь холбогдсон хэргийг тоочин бичиж, улмаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн ямар зүйл ангиар шийтгэл оноосон тухай тэмдэглэл байх амуу.

Порт Артурын хэрэгт холбогдсон хятад иргэдийг байцаах явцад хятадуудын хууль бус үйл ажиллагааны талаар ч мэдээлэл гарч ирж байжээ. Нэгэн жишээ татваас: Порт Артурын хэргийн 2 дугаар ээлжид шийтгүүлсэн 27 хүний нэг Го-Жин овогтой Го-Юу-Зан гэгчийн байцаалтын явцад Хар тамхины хэрэг илэрсэн байна. Го-Юу-Зан нь 1898 онд төрсөн, 1919 онд Монголд ирсэн, зах дээр хувийн дэлгүүртэй, Сүрэн гэх монгол эхнэртэй. Тэрээр 7-8 кг хар тамхи (1кг нь 20.000 төг. үнэтэй) Ши-Жин-Лүү гэгч нийлүүлэгч, борлуулагч гэдгийг илчилсэн байна. Го-Юу-Зан нь хар тамхины хэрэгт орооцолдсоноо бол зөвшөөрнө, харин тагнуулыг хэргийг хүлээн зөвшөөрөхгүй гэж мэдэгдсэн байна¹⁰.

Ингээд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраас томилогдсон Тусгай

⁹ ТЕГ ТА, Ц.8102, хадгаламжийн нэгж 1239. ДЯЯ 3 дугаар хэлтэс. Жү овогтой Жүн-нөн-гүйг мөрдөн байцаасан хэрэг. 155 хуудас бүхий

¹⁰ ТЕГ ТА. Сан 4. Ц. 8803 (22), тал 86

шүүхийн 1949 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн Эрүүгийн хэргийн тогтоолоор янз бүрийн хэмжээтэй хүнд ял оноожээ. БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1949 оны 7 сарын 2-ны өдрийн 30 дугаар тогтоолоор буудан алах ял авсан нэр бүхий 18 хүний амь гуйсныг хэрэгсэхгүй болгожээ.

Ингээд Порт Артурын хэргийн 3 ээлжийн мөрдөн байцаалтыг хэрэг нэг бүрийг¹¹ тоочин бичих нь энэ удаад илүүц хэрэг мэт. Харин эл хэргийн ажиллагааг удаа даараа нэхэн шалгах явцад уг хэргийн дүр төрх болон зохиомол хэргийг хэргийг хэрхэн бий болгож байсныг тольдон харах боломжийг олгоно.

2. Порт Артурын хэргийн ажиллагааг нэхэн шалгах болсон нь

2.1. ДЯЯ-ны шалгалт

Өмнө дурдсанчлан Зөвлөлтөд хэрэгжүүлж буй хамтын удирдлагын зарчмыг Монголд мөн хэрэгжүүлж, намын амьдралыг ардчилах, зарим хэлмэгдлийн хэргийг шалгаж, гэм буруугүй хүмүүсийг цагаатгах ажлыг Намын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Д.Дамбын санаачилгаар хийж эхэлжээ. Үүний хүрээнд ДЯЯ сайдын 1954 оны 3 сарын 1-ний өдрийн 014 тоот тушаалаар томилогдсон Насалжав даргатай комиссоос 1954 оны 3 сарын 2-ноос 6 сарын 24-ний өдрүүдэд Порт Артурын хэрэгт шалгалт хийгээд дүгнэсэн нь¹²:

А) Порт Артурын хэргийн идэвхтэй удирдагч гэж тооцогдсон Жү-шин-гүй нь Хэнтий аймагт амьдралаа хөөцөлдөн ажиллаж байх үед нь мэдээлэгч Буу-д даалгавар өгч хотод ирүүлэхээр түүний ах болох Жүн-нөн-гүйд ятгалга хийлгэж байсан боловч ах нь дүүгээ хотод ирүүлэхийг шууд татгалзаж байжээ. Мөн хэргийн өөр нэг удирдагч гэж тооцогдсон Жан-сан-мугийн анкетыг Минжүүр бичиж авах гэхэд нь Жан-сан-му нь: “...миний ажилладаг 10 жилийн сургууль намайг үнэлэн үздэг” хэмээн маршалын байранд ажиллахаас шууд татгалзсан байдаг. Ийм байсаар байтал Жүн-нөн-гүйг террорын сэжиглэлээр прокурорын зөвшөөрөлтэйгөөр дайчилсан нь буруу зүйл болсон.

Б) Порт Артурын хэрэг дээр мөрдөн байцаалт явуулагчид нь хуулийн бодлого зарчмыг зэрлэгээр гуйвуулан хэрэгтний биеийг хэрцгийгээр зодон занчих, өлсгөх, согтоох, хар тамхи татуулах, хүйтэн карцер¹³ хорих, айлган сүрдүүлэх, албадан хавчих, хөтлөн тулгах зэрэг жигшүүрт аргуудыг өргөн хэмжээтэй хэрэглэх замаар “Гоминданы тагнуулын алан хядах, хорлон сүйтгэх, галдан шатаах, тагнан турших хувьсгалын эсэргүү тагнуулын байгууллага” гэдгийг бий болгосон нь олон баримтаар нотлогдов.

В) Худал хэргийг баримтжуулах зорилгын дор ямар ч холбогдолгүй бөгөөд хувийн хэргээр хөдөө аймгуудад явсан хүмүүсийг гадаадтай тагнуулын харилцаа барьсан болгуулах, урьд хувьдаа буутай байсан хүнийг ёс бусаар урьдчилан байцааж, буу байгааг нь сэжиглэн мэдээд дараа нь ялан хядах зорилгоор зэвсэг бэлтгэсэн болгож гүгэн хэрэгт хамааруулж байснаар барахгүй олон тооны цэвэр

¹¹ ТЕГ ТА. Хуучнаар: НАХ Байгууллагын Улсын Архив. Дотоод Явдлын Яам. Гүйцэтгэх хэлтэс, Фонд 1

¹² ТЕГ ТА. Сан 4.Ц. 8803 (22) Порт Артурын хэргийн 2 дугаар ээлжийн 27 хүнд холбогдох хэргийг шалгасан тухай нэгдсэн тодорхойлолт. Тал 131

¹³ Карцер гэдэг нь ганц хүн зогсоогоор байдаг хавчиг, битүү тасалгаа, хамгийн зовлонтой хорих байр юм.

хүмүүс дээр огт оргүй зохиомол материалыг дайчлах тогтоолд бичиж тэдний эрхэнд зүй бусаар халдан дайчилж байжээ.

Зохиомолхэргээуламгүнзгийрүүлэхийн тулд Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор буудагдах ял нь батлагдсан, энэ хэргийн толгойлогч хэмээх Жү-нөнгүй, Жан-р-хо нарыг 5 сар шахам сайн бололцоогоор хангаж, цаашид хүмүүсийг гүжирдэн гүтгэх зэвсэг болгон ашиглаж байжээ.

В) Порт Артурын хэргийг зохиомлоор бий болгогчид нь өөрсдийнхөө гэмт явдлыг илрүүлж болох талтай явдал бүхнийг таслан зогсоохын тулд байдаг арга ухаанаа сүвэгчилж байжээ. Тухайлбал, Порт Артурын хэрэгт ДЯЯ мэдээлэгч байсан 28 хүн оролцжээ. Эдний 22-ыг нь аль болохоор хүндрүүлэн дээд хэмжээгээр шийтгүүлэхийн тулд хамгийн хүнд үгтэй нууц захиаг зөвхөн тусгай шүүхийн даргад нууцлан өгч анхааруулж байжээ¹⁴. Энэ нь гэрчээ устгах ажиллагаа байсан мэт.

Нөгөө талаар энэ хэргийн худал болохыг илрүүлэн хэлэхийг оролдсон хүмүүсийг үндэслэх шалтгаангүйгээр Дотоод яамны аппаратаас халах, заримыг нь гүтгэлгийн уран арга хэрэглэн холбогдолтой болгон дайчилж, улмаар Гоминданы тагнуулын хэрэг гэдэгтэйгээ холбогдуулан шийтгэхийг оролдож байсныг тухайн хэргийг 1954 онд шалгасан комиссоос дүгнэсэн нь байна.¹⁵

Мөн тус комиссоос Порт Артурын хэргийн боловсруулалт, мөрдөн байцаалтын байдлыг шалгасан тухай дүгнэхдээ: "... хэргийн боловсруулалт нь ганц мэдээлэгч Буу-гийн ямар ч шалгарсан баримтгүй мэдээллээр бүрдсэн бөгөөд Буу нь өөрөөр хятад хэл мэдэхгүй хүн байсан ба өгч байсан мэдээлэл нь тэдгээр хятадуудаас ямар нэг тагнах, алан хядах эрмэлзэл байсан тухай сэжигтэй зүйл ч байгаагүйгээр барахгүй худал мэдээлэл өгч байсан нь тухайн үедээ илрэгдэж байжээ" гэсэн байна.

"Порт Артурын" гэгч Гоминданы тагнуулын байгууллага Монгол улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагдан ажиллаж байсан гэх хууль ёсны нотлох баримт байхгүй нь шалгалтаар илэрсэн, харин тийм том хэрэг буй болгох явдал дээр тэр үед ДЯЯ 3 дугаар хэлтсийн дарга байсан Ч.Мэнд, тасгийн дарга Н.Рэнцэндоо гэх мэт нэр алдар горилсон хүмүүсийн зохиомол материал буй болгох, хөтлөн гүнзгийрүүлэх, хууран мэхлэх, хүч хэрэглэх аргаар мөрдөн байцаалт явуулж, хууль бус аргаар нотлох баримт бүрдүүлж гэм буруугүй олон хятад иргэдийг хохироожээ.

Энэ хэргийг таслан шийтгэхээр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан Тусгай шүүх энэ хэргийг 3 ээлж болгож таслан шийдвэрлэхдээ үнэн мөнийг өөрийн эрх мэдлийн дагуу нягтлан хянаж үзэхийн оронд бусдыг гүтгэгч этгээдүүдэд сохроор итгэж байсан нь олон баримтаар харагдаж байна. Түүнчлэн тухайн үед прокурор энэ хэргийн мөрдөн байцаалтын ажилд тодорхой хяналт тавиагүй, зохиомол шалгагдаагүй зүйл дээр ямар ч судалгаа дүгнэлтгүйгээр дайчлах эрх олгож хөтлөн гүтгэгч нарт улам бүр урамшил төрүүлж тэднээс гэмт хэргийг гүнзгийрүүлэхэд нь зохих нөхцөл боломж олгож байсан нь буруу байна¹⁶ гэж ДЯЯ санаачлан хэрэгжүүлсэн энэхүү ажиллагааг бүхийд нь буруутгасан дүгнэлт гаргажээ.

¹⁴ ТЕГ, ТА, Сан 4, МБХ 10281-ийн 34 дугаар хавтас, т. 5-15

¹⁵ ТЕГ, ТА, Сан 4, МБХ 10281-ийн 34 дугаар хавтас, т. 15

¹⁶ ТЕГ, ТА, мөн тэнд

2.2. Намын Төв Хорооны шалгалтын дүгнэлт

1954 онд МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар сонгогдсон Д. Дамба Намын Төв Хорооны товчооны хурлаар “Порт-Артурын хэрэг” гэгчийг судлан шалгах комиссыг байгуулсан тогтоол гаргуулан авчээ. 1954 оны 12 сард хуралдсан хаалттай хуралдаанаар Порт Артурын хэргийн талаар ДЯЯ өөрөө шалгаад уг хэргийг хилс зохиомол худал байжээ гэдгийг урьдчилан тогтоогоод, “цааш төгс шийдвэрлэх эрх мэдэл бүхий дээд комисс томилон шалгах нь зүйтэй байна” гэсний дагуу комисс байгуулан ажиллуулсан байна. Уг комисс нь Гоминданы тагнах, диверс алан хядах зорилго бүхий томхон байгууллагыг бий болгосон гэдэг нь үнэн хэрэг дээрээ үндэслэлгүй¹⁷ бөгөөд батлагдаагүй байна гээд доорх зүйлсийг санал болгожээ.

-Хариуцлага алдсан ДЯЯ сайд Цэдэв, Дүйнхоржав, Батаа, Улсын прокурор Жамбалдорж, Дагва-жамц, тусгай шүүхийн дарга Цэдэн-норов нарт арга хэмжээ авч, хатуу донгодох;

-Энэ хэрэгт хилс шийтгэгдэж одоо яс цоожинд хоригдож байгаа 32 хятад иргэнийг цагаатган суллаж, тэд нарын хураагдсан хөрөнгө болон хоригдон хөдөлмөрлөсөн хугацааны хөлсийг улсаас эргүүлэн олгуулах, мөн дээд хэмжээгээр шийтгэгдсэн (цаазлуулсан-Ж.У.) хүмүүсийг холбогдолгүй болгон цагаатгаж, тэд нарын гэр бүлийн хүмүүсээс өнчирсөн олон хүүхэдтэй зэрэг онцын гачигдал бүхий хүмүүст эд мөнгөний тусламж үзүүлэх. Суллагдах хүмүүст 3000 төгрөгийн тэтгэвэр олгох;

- Энэ гэмт хэргийн гол эзэд Мэнд, Рэнцэндоо, Дэмбэрэл нарыг эрүүгийн хариуцлагад татах;

-ДЯЯ ба Шүүх Прокурорын байгууллагуудын ажлын завхрал, доголдлыг арилгах, тэдгээрийн ажиллагааг үндсээр нь сайжруулах хийгээд ялангуяа хөдөлмөрчдийн эрх ашгийг хүндэтгэж хамгаалах, хуулийн үндсэн зарчмыг ухралтгүй биелүүлэх, Дотоод яамны удирдлагаас хэрэгтнийг зодох зэрэг хууль бус арга хэрэглэх тухай зөвшөөрөл олгодог явдлыг бүрмөсөн хориглон зогсоох¹⁸ гэсэн саналуудыг тавьжээ¹⁹.

Эцэст нь НТХ-ны шалгалтын комисс эл хэргийг Мэнд, Рэнцэндоо нар Улсыг аюулаас хамгаалах байгууллагад хариуцлагатай албан үүрэг гүйцэтгэж байгаагаар далимдуулан гүйцэтгэх тагнуулын ажлын арга хэлбэрийг хувийнхаа эрх ашигт ичгүүргүй урвуулан ашиглаж зориуд санаатайгаар гүтгэн хөтлөх замаар энэ хэргийг буй болгож, хуулийн ариун зарчмыг олон талаар зөрчиж, улмаар үүсгэгдэн шалгасан хэрэг нь зохиомол хэрэг мөн гэж үзэж байна. Иймд Жүн-Нен-Гүй нарын 28 хүнд оноосон БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 47,57,62-67 дугаар зүйлүүдээр ялласан хэргийг хэрэгсэхгүй болгож, ял шийтгэлийг цагаатгуулахаар болжээ²⁰. Өөрөөр хэлбэл Порт Артурын хэргийн нэгдүгээр ээлжид хамрагдан шийтгэгдсэн хүмүүсийг 28 хятад иргэнийг цагаатгах асуудлыг шийдвэрлэсэн байна.

Зохиомол хэргийг зохион байгуулсан, түүнд оролцсон ДЯЯ ажилтнуудыг шийтгэсэн нь

¹⁷ ТЕГ, ТА, Сан 4, Ц.8103, 22, т. 134-167

¹⁸ ТЕГ, ТА, Сан 4, МБХ 10281-ийн 33 дугаар хавтас, тал 1-134

¹⁹ 1942 онд Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны нууц тогтоолоор хэрэг хүлээлгэхийн тулд сэжигтнийг зодож, занчихыг зөвшөөрсөн байв..

²⁰ ТЕГ, ТА, Сан 4, хн Ц.8102, тал 8

1955 оны тавдугаар сард Намын Улс төрийн Товчоо энэ хэргийг шалгасан комиссын дүгнэлтийг хэлэлцэж, хилсээр шийтгэгдсэн хүмүүсийг суллан тавих, хууль ёсыг бүдүүлгээр зөрчсөн ДЯЯ-ны холбогдох ажилтнуудад хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргажээ. Үүнээс улбаалан, ДЯЯ-ны дэргэд түүний ажлыг хянан шалгах тусгай комиссыг татан буулгаж, Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэд цагаатгалын ажлын комисс болгожээ. Ингэж Сталиныг тахин шүтэж байсан явдлыг шүүмжилсэн ЗХУ КН-ын XX их хурлаас өмнө* Монголд цагаатгалын ажил эхэлсэн байна.

МАХН-ын Төв Хороо Порт Артурын хэрэгт холбогдсон хүмүүсийг байцаасан ажилтнууд хэн хэнийг хэрхэн байцааж байсан талаар судалгаа гаргуулан авчээ²¹ Түүнд доорх 10 хүн оржээ: ДЯЯ мөрдөн байцаагч Дамдинбазар 20 хүн байцааснаас буудагдсан-5 хүн, 25 жил хоригдох-3, 15 жилээр-8, 10 жилтэй 4 хүн. Бандхүү 18 хүн байцааснаас буудагдсан-7, 25 жилтэй -2, 15 жилтэй -4, 10 жилтэй -5. Банд 3 хүн байцааснаас 2-ыг буудсан. Готов 6 хүнийг Мэндийн хамт байцааснаас бүгд буудагдсан. Дэчин 2 хүн байцааснаас 1 нь буудагдсан. Гонгор 2 хүн байцааснаас 1 нь буудагдаж, нөгөөх нь 25 жилийн ял авсан. Гонгор 2 хүн байцааснаас 1 нь буудагдаж, 1 нь 25 жилийн хорих ял. Хишигт 3 хүн байцааснаас 2 нь буудагдсан. Мягмаржав 2 хүн байцааж 20 жил, Сономцэрэн 1 хүн байцааж 25 жилийн хорих ял, Намсрай 1 хүн байцааж буудан алах ял оноожээ. Намын Төв Хорооны Улс Төрийн Товчоод энэхүү жагсаалтыг гаргаж өгсөн Цэргийн ба Нийгмийн аюулаас хамгаалах хэргийг эрхлэх яамны сайд, хошууч генерал Дорж 1956 оны 5 сарын 31-ны өдөр дээрх байдлуудыг илтгэн танилцуулж, дурдсан нэр бүхий 10 хүнийг тус аппаратаас зайлуулах саналтай байгаагаа илтгэжээ.²² Саналыг ажил хэрэг болгосон байна.

Мөрдөн байцаах хэлтэст хянагч байсан Бэгзжав: шоронгоос дарга байцаагч нарт хэрэгтнийг хүргэж өгч, буцааж авчирдаг ажилтай байсан. Хэрэгтэн Жүн-нөн-гүй нь Мэнд, сургагч Зоботин, Жао нар дээр байцаагдаж байсан юм. Дарга нар надыг их зодож байна гэж ярьдаг байсан юм. Байцаалтад очихдоо хамаг бие нь чичрээд маш их айж, Мэндийн тасалгаанд орохоосоо айгаад, орж чаддаггүй байсан. Ер нь шилний хагархай идэх, боох зэргээр үхэхийг үргэлж оролддог байсан. Рэнцэндоо нь хэрэгтнийг их зоддог байсан. Бандхүүгийн байцааж байсан нэг хятад боож үхсэн. Шээс нь гарахгүй, их халуунтай, гэдэс нь өвдсөн зэрэг хүнийг эмнэлэгт үзүүлдэггүй байсан. Хэрэгтний хоолыг их хасдаг, хүйтэн карцерт 1-3 хоног хүртэл дан хувцастай хорих, өглөөний 10, 11 цагаас оройн 6,7 цаг хүртэл, мөн оройн 10 цагаас маргааш өглөөний 6 цаг хүртэл гол төлөв байцаадаг (өдөрт 10 цаг байцах) гэжээ.²³ Карцерт гал түлдэггүй, цементэн шалтай, дэвсгэргүй, хүнийг дан өмд цамцтай, оруулж түгжээд осгоодог, хоол өгдөггүй, өдөрт аяга ус зүсэм талхтай өгдөг, энэ байр 1949 он хүртэл ашиглагдаж байв²⁴.

1949 онд Порт Артурын хэрэг гэгчид холбогдож ял шийтгэгдээд ялаа эдэлж байсан хоригдлуудаас 1955 онд өөрсдөө хилс хэрэгт тулгагдан хохирсон тухай тодорхойлон бичсэн баримтууд мөн Архивд хадгалагдаж байна. Тэдгээрээс үзэхэд эл хэрэгт холбогдон суусан цагаасаа эхлэн хилс хэрэгт гүтгэгдчихлээ хэмээн удаа дараа Өргөдөл өгч байсан хүмүүс ч байна. Гэвч 1955 оноос өмнө тэдний Өргөгдлийг огт авч хэлэлцдэггүй, хариу ч өгдөггүй байжээ.

* ЗХУ КН-ын XX Их Хурал 1956 оны 2 сарын 14-25-нд Москва хотноо хуралдсан

²¹ УТА Ф 4, Т.23, хн 43, тал 124-126

²² УТА Ф 4, Т.23, хн 43, тал 124-126

²³ ТЕГ, ТА, Сан 4, МБХ 10281-ийн 31 дугаар хавтас, хуудас 36-37

²⁴ Т.Гэндэн, 1999.Гурван түмэн хүний амь. Улаанбаатар

Порт Артурын хэргийн 2 дугаар ээлжид шийтгэгдсэн 27 хүний 19 нь Жүн-нөн-Гүй, Жан-р-хо, Жан-сан-му, Жүн-шин-гүй нарт элсэгдсэн, 4 нь хэнд ч элсэгдээгүй гэж мэдүүлэг гаргасан бөгөөд Шүүхийн таслан шийтгэх хурал дээр 10 гаруй хүн ямар ч хэрэг хүлээгээгүй байна. Гэтэл эдгээр 27 хүний 18-д нь буудан алах ял, 9-д нь 20-25 жил хорих ял оногдуулсан байна.²⁵

Порт Артурын хэрэг гэгчийг анх буй болгож, зохиомлоор хэрэг бүрдүүлсэн, хилс ташаа хэрэг хүчээр хүлээлгэсэн, олон хүний амь амьдралд хохирол учруулсан ДЯЯ-ны III хэлтсийн дарга агсан Ч.Мэнд, мөн хэлтсийн төлөөлөгч, тасгийн дарга агсан Н.Рэнцэндоо, мэдээлэгч Дэмбэрэл нараас эрүүгийн хэрэгт татагдан мөрдөн байцаалтад өөрсдийнхөө бузар үйлдлүүдээ бүрэн хүлээсэн байна. Тухайлбал, Дотоод явдлын яамны 3 дугаар хэлтсийн дарга байсан Мэнд мэдүүлэгтээ:

А) Жүн-Нен-Гүйг Японы Гоминданы тагнуул болохыг шалгаж тогтоосон баримт байхгүй. 17 дугаар армиас ирсэн, Жүн-Нен-Гүйн тухай справканы (лавлагаа-Ж.У.) орос эх нь хаана байсныг мэдэхгүй, сургагч нар дээр байсан болов уу. Жүн-Нен-Гүй, Жан-Сан-Му хятад Самбуу гэх Ли-Юу-И-тэй холбоотой байсан гэж буруу ойлгож байжээ. Самбуугийн мэдүүлэгт ийм зүйл байхгүй байсан нь батлагдсан явдал бол Порт Артурын хэргийн худал зохиомол болохыг бас нэг шалтгаан болсон байна.

Б) Гоминданы тагнуулын газарт Го-Юу-Пай гэдэг хүн байсан эсэх, түүнээс Жүн-Нен-Гүй даалгавар авсан эсэхийг шалгаж тогтоогоогүй, би “мэдээлэгч Б.Дэмбэрэлийг хэрэгтэн Жүн-Нен-Гүй, Жан-Сан-Му, Жүн-Шин-Гүй нартай нүүрэлдүүлэхдээ ийм ийм зүйлүүдийг хэл” гэж зааж өгч урьдчилан бэлтгүүлж байж нүүрэлдүүлсэн нь үнэн, мэдээлэгчийн мэдээллээр зөвхөн цуурхлын төдий зүйл зарим хүмүүс дээр гарч байснаас өөр батлах юм байгаагүй.

В) Жүн-Нен-Гүйн мэдүүлэг бол хүчинд автагдсаны улмаас гаргасан мэдүүлэг гэж үзэж болно. Жүн-Нен-Гүйн 52 дугаар мэдүүлгийг би сургагч Золотин, туслах сургагч Жо, Н.Рэнцэндоо, Доржиев бид нар зодож, өөрийн Тагнуулын байгууллагад олон гишүүн хүн байгаагаар нэр гаргасныг 53 дугаар мэдүүлгээр тодруулж авсан, хэрэгтнийг зодож байгаад дараа нь асуулт тавихад тавихад “тийм тэгсэн” гэж хариулдаг байсан гэжээ²⁶.

Цэндийн мэдүүлэгт: Жүн-нөн-гүй нарын хэргийг бүртгэхдээ хэрэг хүлээгээгүй болохоор нь зодож хүлээлгэсэн явдал бий бөгөөд ”Порт Артур” хэргийн боловсруулалтыг дан ганц мэдээлэгчийн мэдээллээр үндэс болгосон нь их буруугийн үндэс болсон юм. Мэдээлэл нь зөвхөн цуурхлын төдий юм. Зарим нэг хүн дээр илэрч байснаас өөр батлах юм байгаагүй... Жүн-нөн-гүй-гээс анх өөрийн тагнуулын байгууллагад элсэгдсэн гэж 4 хүний нэр гаргасан мэдүүлгийг зодож байж гаргуулсан нь үнэн. Ийм учраас Жүн-нөн-гүйн энэ мэдүүлгийг хүчинд автагдсаны улмаас гаргасан мэдүүлэг гэж үзэх болно.

Би мөрдөн байцаагч нарт үүрэг өгөхдөө заавал хэрэг хүлээлгэх хэрэгтэй гэдэг байсан. Харин үнэн эсэхийг нь тогтоох талаар анхааруулж даалгаж байсан удаагүй. Жүн-нөн-гүй мэдүүлгээр хүний нэр илэрсэн байна. Ер нь энэ хэргийн буруу болохын нэг сүрхий үндсийг Рэнцэндоо мэдээг нь барьж байгаад иймд хүргэсэн зүйл бий гэж бодно. Ингэхдээ би өөрөө хариуцлагаас зайлсхийж байгаа хэрэг биш гэх зэргээр мэдүүлсэн байна.²⁷

²⁵ ТЕГ ТА, Ц.68103, тал 152

²⁶ ТЕГ ТА. Сан 4, Ц.8102, тал 15

²⁷ ТЕГ ТА. МБХ 15192, тал 1-156

ДЯЯ мэдээлэгч Б.Дэмбэрэлийг гардан удирдаж байсан Н.Рэнцэндоо мэдүүлэхдээ: “Порт Артурын хэргийн эхэлж нээхдээ үндэсгүй нээсэн юм. Мэдээлэгчээс над хураагдсан материалуудад тагнан турших, алан хядах, тийм байгууллагын талаар ямар ч мэдээлэл байгаагүй” гэжээ. Түүнчлэн тэрээр энэ хэргийн эх үүсвэрийг ярихдаа 1947 оны 9 сарын орчимд мэдээлэгч Б.Дэмбэрэл нь нөгөө Самбуугийн найз хятад Жан-Сан-Му зах дээр надтай уулзаад миний хамт худалдаа хийдэг Жүн-Нен-Гүй албан журмын хөдөлмөрт хөөгдөх гээд байна. Ажил мэдэж байгаарай гэж захиж байна гэсэн юм. Би түүнийг нь мэдээ болгон бичиж хэлтсийн дарга Ч.Мэндэд өгөхөд тэр сургагчтай зөвлөж ирээд Б.Дэмбэрэлийг Х.Чойбалсангийн байранд ажилладаг, манай тэнд усан пийшингийн галч, тогооч, цэцэрлэг усалж, тахиа маллах зэрэг ажлын орон тоонууд байна гэж яриулах даалгаврыг надаар дамжуулж өгсөн юм” гэжээ.

Б.Дэмбэрэл Жүн-Нен-Гүйтэй очиж уулзаад Жүн-Нен-Гүй өөрөө ажилд орж, тохирох мэргэжлийн хүмүүсийг олж өгч болно гэсэн байсныг үндэслэн хятадын зураг, өргөдөл, анкетыг авч лабораторийн ажилтан Минжүүр гэгчийг маршалын байрны комендант нэрээр Б.Дэмбэрэлийн гэрт хятадуудтай уулзуулж яриулаад боловсруулах хэрэг нээж ямар ч үндэсгүй баримт материалаар дайчилгаа явуулж Гоминданы тагнуулын ба алан хядах нэг том байгууллагыг устгах нэрээр хувьсгалт хууль ёсны зарчмыг зөрчин холбогдогчдыг байцаахдаа айлган сүрдүүлж тулган шахах, хөтлөх, гүтгэх, зодох, мэдүүлгийг зохиож бичих аргуудыг хэрэглэж байсан нь үнэн гэжээ.²⁸ Ийнхүү Ч.Мэнд, Н.Рэнцэндоо, Б.Дэмбэрэл нар албан тушаалаа хортойгоор ашигласан, мөрдөн байцаалтыг хууль бусаар явуулсан, бусдыг хүнд гэмт хэрэгт гүтгэсэн хэргээ хүлээж, Тусгай шүүхийн 1955 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 3 дугаар тогтоолоор шийтгэгдэж, Ч.Мэнд, Н.Рэнцэндоо нар 8-6 жилийн хорих ял шийтгэгдсэн байна²⁹.

3. Порт Артурын хэргийн хоёрдугаар ээлжид баригдан шийтгүүлсэн 27 хүнд холбогдох хэргийн ажиллагааг үүсгэн шалгасан нь

Хэргийн ажиллагааг үүсгэж шалгах болсон шалтгаан

1990 оны 12 дугаар сард Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс байгуулагдан улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх, тэдэнд нөхөн олговор олгох талаар нэлээд ажлыг хэрэгжүүлж эхэлсэн юм³⁰. Төр засгийн санал санаачилга, хүний эрхийн олон нийтийн байгууллагууд, хэлмэгдсэн олон мянган иргэдийн болон тэдний ар гэрийнхэн хүсэлт, шаардлага тавьж улс төрийн хэрэгт холбогдсон бүх иргэдийн хэргийг нарийвчлан нягтлан шалгахыг шаардаж байлаа.

²⁸ ТЕГ ТА, мөн тэнд, тал 7

²⁹ ТЕГ ТА, мөн тэнд. Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол, дугаар 372. 2001 оны 10 сарын 15

³⁰ З.Лонжид нар. Хэлмэгдэл ба цагаатгал: түүх ба баримт. УБ.,2020, тал 269

Монгол Улсын ерөнхийлөгчийн 1990 оны 56 дугаар зарлигийн дагуу иргэн Х.Баттөмөрийн³¹ өргөдлийн үндсэн дээр шинэ учир байдал илэрснээс хэргийн ажиллагааг үүсгэн явуулах тухай Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурорын 1994 оны 8 сарын 25-ны өдөр ирүүлсэн тогтоолыг үндэслэн Порт Артурын хэрэг гэгчийн хоёрдугаар ээлжид баригдаж шийтгэгдсэн Ши-ван-хүй, Жү-хуа-тэн, Хан-чин- дай нарын 27 хүний 10281 тоот мөрдөн байцаалтын хавтаст хэргүүд болон бусад холбогдох баримтад тулгуурлан шалгалт явуулжээ*. Эдгээр хоёрдугаар ээлжийн хүмүүс 1948 оны 9 сарын 11-нээс 1949 оны 4 сарын 28-ны хооронд баривчлагдсан. Өмнөх 1 дүгээр ээлжээр шийтгэгдсэн Жү-мөнгүй, Жан-р-хо, Жан-сан-мао нарт эзлэгдсэн ба нэр илэрсэн гэсэн зүйл тэднийг баривчлах шалтгаан болсон байв. Улмаар Улсын Бага хурлаас томилогдсон тусгай шүүхийн 1949 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн тогтоолоор эрүүгийн хэрэг үүсгэн шийтгэгдсэн байсан амуй.

Ингээд эл хэргийг 1994 онд Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтсийн Цагаатгалын тасгаас 1994 онд шинэ нөхцөл байдлаас хэрэг үүсгэж шалгаад нэгдсэн тодорхойлолт гаргажээ. Түүнд: “Жү-Нөн-Гүйгээр удирдуулсан гоминданы тагнуулын үлдэгдэл нэг хэсэг гэж шийтгэгдсэн 2 дугаар хэсгийн нэр бүхий 27 хятад иргэдийг дайчлан баривчлахаас урьд гоминданы тагнуулын байгууллагын алан хядах, галдан шатаах, хорлон сүйтгэх салбар хэсэг буй болж тус орны хот хөдөөд зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж, улс оронд хохирол учруулж байсан тухай мэдээ материал тухайн үеийн Дотоод явдлын яамны байгууллагад байгаагүй болох нь өмнөх буюу 1954 онд, мөн энэ удаагийн буюу 1994 онд “Порт-Артур”-ын хэргийн боловсруулалт, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар тогтоогджээ.

1994 оны шалгалтын дүгнэлтэд: Хятад улсын иргэн Жү-Нөн-Гүйгээр удирдуулсан гоминданы тагнан турших, алан хядах, хорлон сүйтгэх, хувьсгалын эсэргүү байгууллага гэгч Монгол улсад зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байсныг баталж нотолсон баримт хэргийн материалд авагдаагүй байна.

Дээрх хүмүүст холбогдох хэргийг шалгасан ажиллагаа нь гүйцэтгэх болон нууц тагнуулын ажлын зарчим, зохион байгуулалтын хувьд эхнээсээ буруу байсны гадна Дотоод явдлын яамны 3 дугаар хэлтсийн дарга байсан Ч.Мэнд, түүний удирдлагад ажиллаж байсан Н.Рэнцэндоо нарын хууль зөрчсөн үйл ажиллагаа нь нотлогдож байна.

Порт Артурын хэргийг дахин хянан үзсэн ДЯЯ сайдын тушаалаар 1954 онд томилогдсон комисс, мөн 1955 оны МАХН-ын Төв Хорооны комисс нь уг хэргийг зохиомол хэрэг гэдгийг нотолсон. ДЯЯ-ны 3 хэлтсийн дарга байсан Ч. Мэнд, тасгийн дарга байсан Рэнцэндоо гэх мэт нэр алдар горилсон хүмүүсийн зохиомол

³¹ Порт Артурын хэргийн 2 дугаар ээлжийн мөрдөн байцаалтад орж хохирогч болсон Хан-Чин-дайн хүү Баттөмөр эцгийгээ цагаатгаж өгнө уу гэсэн өргөдөл гаргажээ. Баттөмөр нь Дархан аймгийн Шарын голын уурхайн харуулын албаны цэвэр усны харуул хийдэг байна. Түүний эцгийг 1949 оны 4 сарын 1-нээс 6 сарын 20-ны хооронд 23 удаа байцаасан. Тэрээр Гоминданы тагнуулын ажил хийгээгүй гэдгээ удаа дараа мэдүүлж байсан боловч заримдаа шахалт дор худал мэдүүлж, дараа нь тэдгээрийг үгүйсгэсэн зүйл хэлж байжээ. Эрүүгийн хуулийн 62,67-гоор 20 жил гянданд суулгахаар яллажээ. Хан-Чин-дай нь 1914 онд Монголд хүргэн ахаа даган орж ирсэн, монгол эхнэртэй-нэр нь Цэрэнхүү, 2 хүүтэй (Баттөмөр, Хатанбаатар 6 настай), хувийн дэлгүүр болон гуанзтай байжээ.

* 1994 он гэхэд Порт Артурын хэрэгт гэрч, хохирогчоор байцаах амьд хүн байхгүй болсон байв.

материал буй болгох, хөтлөн гүнзгийрүүлэх, хууран мэхлэх, хүч хэрэглэх аргаар мөрдөн байцаалт явуулж хууль бус аргаар нотлох баримт бүрдүүлж, гэм буруугүй олон иргэдийг хохируулжээ.

Иймд Шин-Ван-Хуй нарын 27 хүнд холбогдох Гоминданы тагнан турших, алан хядах, хорлон сүйтгэх хувьсгалын эсэргүү байгууллагыг зохион байгуулж үйл ажиллагаа явуулж байсан гэж БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 62,64,65,67,68 дугаар зүйлүүдээр яллагдсан, хэрэг нь нотлох баримтаар тогтоогдоогүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх тул хэргийг хэрэгсэхгүй болгож, БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 4 дүгээр тогтоолоор байгуулагдсан тусгай шүүхийн 1949 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хурлын тогтоолоор дээрх 27 хүнд оногдуулсан ял шийтгэлийг цагаатгуулахаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 378 дугаар зүйлийг баримтлан дүгнэлт бичив”³² гэжээ.

Монгол Улсын прокурорын дээрх дүгнэлтийг Дээд Шүүх хүлээн авч, “Порт Артурын” гэх хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй зохиомол хэрэг болох нь нотлогдсон тул уг хэргийн 2 хэсгийн хэргийн тухай 1949 оны 7 сарын 1-ний тогтоолыг хүчингүй болгож, шийтгэгдсэн нэр бүхий 27 хүнийг цагаатгах тухай тогтоолыг Монгол Улсын Дээд Шүүхээс 2001 оны 10 сарын 15-ны өдөр гаргажээ.

Дүгнэлтийн оронд хэдэн эргэцүүлэл бичих нь

БНМАУ-д өгүүлэн буй үед баривчлалтын хэмжээ баригдсан хүний тоо 1942 оны үеэс багассан боловч үндэсгүй хардаж сэжиглэх, гүтгэх, гүжирдэх, зохиомол хэрэг буй болгох, мөрдөн байцаалтад эрүү шүүлт хэрэглэх, хэрэгтэнтэй хүний ёсноос гадуур харилцах явдал 1949 оныг хүртэл үргэлжилж иржээ. Үүний нэг тод илрэл бол “Порт Артурын хэрэг” юм.

Порт Артурын хэрэгт холбогдон маш хатуу шийтгэл хүртсэн хятадууд нь бүгд Монгол улсын иргэн болоогүй, Хятадын харьяатууд байсан нь мөн анхаарал татна. Гадаадын иргэдийг БНМАУ-ын иргэн болгох асуудлыг шийдвэрлэх үүднээс 1926 онд Гадаад Явдлын Яамнаас “Тус улсын хязгаарын дотор суугаа гадаад улсын харьяат нарыг дагуулан явах тухай тогтоосон дүрэм”-ийг батлан гаргасан бөгөөд түүгээр Монгол улсад олон жил суурьшсан, тус улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа болон улс төрийн гэмт хэрэг үйлдээгүй, Монгол улсын харьяат иргэнтэй гэр бүл бололцсон, уг хүмүүний харьяат улсаас тус улсад суугаа элчин сайд, консулын газраас татгалзаагүй тохиолдолд Монголын харьяат болгохоор тогтоосон байдаг³³. Эдгээр шаардлагуудыг хангаад Монголын иргэн болсон хятад хүмүүс ч мөн нэлээдгүй байсан билээ. Тэднээс Порт Артурын хэрэгт холбогдсон хүн байхгүй, харин ДЯЯ-ны мэдээлэгч нар бол байсан бололтой.

Порт Артурын” гэх хэрэг нь “Гоминданы тагнуулын хэрэг”, “Чойбалсангийн амь насанд халдахаар завдсан хэрэг”, “Монголыг хорлон хохироох хэрэг” гэх мэтчилэн хэд хэдэн тодотголтойгоор бичигдсэн байх аж. Өмнө нь ДЯЯ-нд мэдээлэгч гараас авч байсан, ирсэн мэдээлэл дунд иймэрхүү төрлийн мэдээлэл нэг ч байгаагүй

³² ТЕГ ТА. Сан 4. Цагаатгалын 8803 (22). Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол, 2001.10.15, дугаар 372 //Ши-Бу овогтой Шин-Ван-Хуй нарын “Порт-Артурын” хэргийн 2 дугаар хэсгийн 27 хүнд холбогдох эрүүгийн хэргийн тухай/

³³ Гадаад харилцааны төв Архив. Х-1, д-1, хн 282, нугалбар 2

гэдгийг Дотоод яамны ажилчид өөрсдөө мэдүүлсэн байна. Гэтэл 1947 онд гэнэт Гоминданы тагнуулын хэрэг гэдгийг бий болгож, 6 сарын хугацаанд боловсруулж, дайчилгааг 3 ээлж болгон явуулж, мөрдөн байцаалтыг 1948 оны 4 дүгээр сараас 1949 оны 10 дугаар сар хүртэл явуулж дуусгасан нь тодорхой зорилготой байсан мэт.

Гадаад нөхцөл байдлыг эргэцүүлэн үзвээс, Хятадад коммунистууд засгийн эрхэнд гарч БНХАУ байгуулагдсан (1949.10.1) үеэр Порт Артурын гэх хэрэг дуусгавар болжээ. Тус хэргийн боловсруулалт болон мөрдөн байцаалтын хэрэгт орос зөвлөх, сургагч нар оролцсон нь Архивын баримтаас тодорхой байна. ЗХУ нь Хятадын иргэний дайны эхэн үед гоминдан болон коммунистуудын аль алийг нь дэмжих бодлого явуулж байснаа 1948 оноос коммунистуудын талд орж дэмжлэг туслалцаа үзүүлж, харин гоминданчууд АНУ-тай ойртох болсон байв.³⁴ Ийм нөхцөлд засгийн эрхээ алдаж буй гоминданыхны тагнуулын хэрэг гэдгийг зохиомлоор бий болгох нь хэний сэдсэн, хэний эсрэг ямар зорилгоор хийгдсэн ажил болохыг тодруулах боломж хомс байгаа нь Тагнуулын Ерөнхий газрын Тусгай Архивын нууцын зэрэглэлтэй баримтуудыг үзэж судлах боломж үгүй байгаатай холбоотой юм. Уг нь бол “Төрийн болон албаны нууцын тухай хууль” -ийн дагуу бол баримтуудын нууцлалын хугацаа дуссан, ил гаргаж болон мэт³⁵. Анхдагч эх сурвалжуудыг үзэх, судлах боломж хязгаарлагдмал байгаа учраас олон түмний дунд янз бүрийн үзэл санаа байх агаад тэдгээр нь цахим сүлжээнд нийтлэгдэн гарч байна.

Мөрдөн байцаалтын хэргүүдийн тэмдэглэлээс үзвэл орос сургагч Зоботин, туслах сургагч Жо гэх хоёр хүний нэр гарч байна. Зоботин хэмээн бичсэн нь Б.Зоботин бололтой. Тэрээр 1947-1950 онд ДЯЯ сургагчаар ажиллаж байжээ. ЗХУ-ын Москвагийн заалт орос зөвлөх, сургагч нараар дамжин ирдэг байсныг үгүйсгэх аргагүй. Гэхдээ цаасанд бууж үлдсэн баримт үзээгүй ээ, бид. Манайхан умард хөршийн Троцкистийн хэргээс загвар авч Гэндэн, Дэмидийн хэргийг үүсгэсний нэгэн адил энэ удаад ч тэдний дохио зангаагаар хэрэг үүсгэсэн биш байгаа даа?!

БНМАУ-ын улс төрийн зүтгэлтэн Нянтайширын Лхамсүрэн аругай Порт Артурын хэргийг ДЯЯ гуравдугаар хэлтсийн Цэнд, орос зөвлөх Лангфангийн хамт зохион байгуулсан хэмээн бичсэн байна. Н.Лхамсүрэн дуртгалдаа:” Порт–Артурын хэргийг Ланфанг, Мэнд хоёр зохион байгуулсан юм. Порт-Артурын хэргийг илчилсэн явдал маш их нарийн байдалтайгаар зохион байгуулсан болгож, түүнийг Аюулаас Хамгаалах Академид хамгийн үлгэр жишээ классик ажиллагаа болгож, Ланфангийг шоронд орох хүртэл нь Ланфангийн арга барил “Метод Ланфанга” гэж хичээл зааж байсан юм. Тэр хэргийг их гоёор зохион байгуулсан юм”³⁶ хэмээн өгүүлсэн байна. Н.Лхамсүрэн аругай Зөвлөлтийн Аюулаас хамгаалах байгууллагын ажилтан, дэслэгч генерал Александр Иванович Лангфанг (1907-1990)-ийн талаар мөн ийнхүү бичжээ: “Тэрээр цааш нь өгүүлэхдээ: “Ланфанг бол эхлээд Ягод, түүний дараа Ежов, түүний дараа Бериягийн баруун гар болж байсан

³⁴ Борисов О.Б,1980. Советско-китайские отношения (1945-1980). Москва. Тал 35-36

³⁵ Мэдээллийг нууцлах хугацаа: “онц чухал нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл - 30 жил; “маш нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл - 20 жил; “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл - 10 жил гэж хуульд заасан

³⁶ УТА. Ф.20, т.1, хн 528 . Ахмад түүхч Нянтайширын Лхамсүрэн (Дуртгал) 1989 оны 10 сар. Ярилцсан Л.Бат Очир

хүн байгаа юм. Тэр бол сүүлд нь Коминтерны улсуудыг хүйс тэмтрэх санаатай гүтгэлгийн материал бүрдүүлж байгаад ажилгүй болоод манайд ирж Балдаа / Цэдэнбал/ бамбай болж, Чойбалсанг харж харгалзах зорилгоор Балдаа замыг нь тавихаар ирээ биз дээ гэж би боддог юмаа. Ланфанг сүүлдээ Хятадын аюулаас хамгаалах яамны зөвлөхөөр очсон. 1954 онд би ерөнхий сайдын орлогч, Гадаад яамны сайд, засгийн газрын төлөөлөгчөөр гэрээнд гарын үсэг зурахаар Бээжин явлаа даа. Тэнд Ланфанг Цэдэнбал хоёр хэдэн цаг ярьсан, юу ярьсныг нь би мэдэхгүй, тэд их архидсан”³⁷ гэжээ.

Порт Артурын хэрэгт Ю.Цэдэнбалыг хамаатуулан бичсэн өөр зүйл ч мөн үзэгдэнэ. Д.Дамбын санаачилгаар ДЯЯ үйл ажиллагааг шалгах комисс байгуулагдан ажиллаж байсан тэр үеийн талаар: “...Цэдэнбал бухимдаж эхлэв. Юуны өмнө “Порт-Артурын хэрэг” гэгчид тэр оролцоотой байсан бөгөөд Дамбыг өөрийг нь ухаж, төнхөх гэж санаатайгаар ийм ажил санаачлаад байна гэж тэр бээр хардаж эхэлжээ. 1942 онд Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны нууц тогтоолоор хэрэг хүлээлгэхийн тулд сэжигтнийг зодож, занчихыг зөвшөөрсөн байсан бөгөөд энэ тогтоолд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, Ч.Сүрэнжав нар гарын үсэг зурчихсан байлаа. Улс төрийн Товчооны хурлаар энэ тогтоолыг хүчингүй болгосон байна. Энэ бүхэн аажмаар улс төрийн хэлмэгдүүлэлтэд Ю.Цэдэнбал холбоотой байжээ гэсэн сэдэв гаргаж ирэх Дамбын далд явууллага байна хэмээн Цэдэнбал хардаж байлаа. 1955 онд хуралдсан бүгд хуралд Дамбын оруулах гэж байсан илтгэлийг Цэдэнбал хянаж, нэлээдгүй зүйлийг хасжээ”³⁸ гэсэн байна.

Намын Хянан шалгах хорооны даргаар ажиллаж байсан Тогоочийн Гэндэн манай улсын түүхэнд цуст мөр болон үлдсэн хэлмэгдүүлэлтийг шалган үзэх комиссыг ахалж ажиллаж байсан юм. Т.Гэндэн аругай дургал номоо 1999 онд гарсан юм. Түүнд: “Дотоод Яам 1948, 1949 онд боловсруулж маршал Чойбалсанг хөнөөх гэсэн хэрэгт зуугаад хүнийг баривчлан харгис, хэрцгий арга хэрэглэн зодож занчих зэргээр тарчилган зовоож хилс хэрэг хүлээлгээд 40 гаруй хүнийг буудан алжээ. Энэ хэргийг шалгахад би оролцоогүй болохоор дэлгэрэнгүй бичихийг түвдсэнгүй. МАХН-ын Төв Хороог удирдаж байсан Дашийн Дамба үнэний төлөө махран зүтгэж, “Порт-Артур” хэргийг шалгуулсан төдийгүй гэм буруутан Дотоод Яаманд байсан харгис хэрцгий этгээд, зүй нь алан хядагч гэж нэрлэгдмээр Мэнд, Рэнцэндоо, Дүйнхоржав, Жамбалдорж, Шагдаржав, Болд, Дэчин нарын зэрэг нэлээд хүнд жаахан ч гэсэн зэмлэл хүлээлгэн, Дотоод Яамны бүрэлдэхүүнээс гаргасан байна.

Олон хүнийг хэлмэгдүүлж цусан зам татуулан төрийн толгойд гарсан Чойбалсанг анх удаа шүүмжлэн бузар булай хэргийг нь илчлэх улбааг Д.Дамба гаргасан юм. Энэ үйл явдал Дамба, Цэдэнбал хоёрыг хоёр тийш нь харуулж улмаар Дамбыг хэлмэгдүүлэн газар нутаг заан зайлуулахад хүргэжээ”³⁹ хэмээн тэмдэглэсэн байна.

Порт Артурын хэргийг үүсгэн бий болгож, ажиллагаа явуулсан нь тодорхой зорилготой байсан мэт. Үүнд тус яамны нэгэн хэлтсийн дарга Мэнд гэгч дангаараа санаачлан хийсэн гэхэд эргэлзэн мунхаглана, би. Гагцхүү бид өдгөө уг хэрэг цаагуураа ямар зорилготой өдөөгдсөний талаар таамаг дэвшүүлэх боломжтой

³⁷ УТА. Ф.20, т.1, хн 528, тал 22

³⁸ С.Баатар, 2005. Эх орончид ба Цэдэнбал. Улаанбаатар, тал 21

³⁹ Гэндэн Т., 1999. Гурван түмэн хүний амь. Улаанбаатар, тал 153

боловч таамгийг ч гэсэн баримт дээр тулгуурлан дэвшүүлэх ёстой. Баримтын сэжүүр ч байхгүй байж сохроор таамаг дэвшүүлэх, хардах зэрэг нь мөн л савангийн хөөс мэт зүйл юм. Мөн түүнчлэн тухайн түүхэн нөхцөл байдлыг бид бодитойгоор сэргээн тавихыг төлөө л ажиллах ёстой, үүний тулд баримтуудыг гүйцэд үзэх шаардлагатай байдаг билээ.

Порт Артурын хэрэг нь “Манай ололт амжилт өсөхийн хэрээр дотоодын дайсны эсэргүүцэл хурцадна” гэсэн онол хил даван орж ирээд зохиомол дайсан бий болгох ажиллагааны нэг хувилбар байв уу? эсвэл Зөвлөлтөд өрнөсөн “Ленинградын хэрэг” гэгчийн нэгэн хувилбар байгаад, Монголын нам төрийн удирдагчдын хоорондын тэмцлийн улбаа байв уу? гэдэг нь асуулт хэвээр үлдэх амуу.

“PORT ARTUR CASE”

Summary

Not only Mongolians but also foreigners who have lived and worked in the country have been affected by the repression, a black spot in 20th Mongolian history. Between 1947 and 1949, 80 Chinese nationals that had resided in the country were accused of being Kuomintang spies. They were interrogated in 3 shifts and punished for crimes such as terrorism, arson and sabotage. The case was named “Port Arthur”.

With the death of Marshal Choibalsan in the People’s Republic of Mongolia and Stalin in the Soviet Union in 1953, the one-man dictatorships were disbanded. The political climate became softer and the principles of collective governance were restored. At that time, the MPRP leadership took the initiative to review cases of the past, mitigating and correcting the consequences of the arrests and tortures that took place in the 1930s and 1940s. The ministry of internal affairs reconsidered the Port Arthur case as part of its investigation and determined that the case was fabricated. At the meeting of the Politburo of the Central Committee of the MPRP on May 18, 1955, the report of the commission investigating the Port Arthur case was discussed and the convicts were released.

In the late 1940s, at the end of the Chinese civil war, when the Kuomintang regime collapsed and the Communists came to power, the ministry of internal affairs created the “Kuomintang intelligence case” out of the third division. Today, it is not possible to know exactly the purpose, the scale of these operations and who commissioned them. We can only speculate. This is because we do not have the right to view all materials in the archives. However, since this case was acquitted, it is possible to see some documents.

Eighty of Chinese nationals were arrested, interrogated and punished by the Ministry of Internal Affairs. Later these cases were found to be fabricated. The documents relating to the acquittal of those convicted under the Criminal Procedure Code are kept in the Special Archives of the General Intelligence Agency and the National Central Archives. As a researcher, I wrote this article because it is right to bring out factual information and bring focus on these historical events. The fact that the case was retried several times, for example, in 1955-1956 and 1994-2001, is an indication that the case is not outdated but will continue until the case is fully resolved.

Keywords: Kuomintang, intelligence, mobilization, repression, atonement, fabrication

Ном зүй:**1. Ашигласан Архивын материал:**

- 1.1. Гадаад харилцааны төв Архив. Хөмрөг 1, данс 1, хадгаламжийн нэгж 282
- 1.2. Тагнуулын Ерөнхий Газар. Тусгай Архив. Сан 4, Мөрдөн Байцаалтын Хэрэг 10281-ийн, хавтас 31; МБХ 15192
- 1.3. ТЕГ ТА. Сан 4. Цагаатгалын 8803 (22); Ц.8102; Ц.68103
- 1.4. ТЕГ ТА. Хуучнаар: Нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын Улсын Архив. Дотоод Явдлын Яам. Гүйцэтгэх хэлтэс, Фонд 1, хн 12392, хавтаст хэрэг 1,2,3.
- 1.5. Үндэсний төв Архив. Фонд 20, товьёг 1, хадгаламжийн нэгж 528; Ф 4, т.23, хн 43
- 1.6. УТА. Ф.286, т.1, хн 112. БНМАУ-ын Прокурорын газар. Хууль цаазын Архиваас ирсэн материал.
- 1.7. УТА.Ф 4, т.23, хн 43. МАХН ТХ УТТ-нд “Порт- Артурын” хэргийг байцаасан хүмүүсийн тодорхойлолт
- 1.8. УТА. Ф.20, т.1, хн 528 Нянтайширын Лхамсүрэн (дуртгал) 1989 оны 10 сар, ярилцсан Л.Бат Очир
- 1.9. УТА. Намын хянан шалгах хорооны баримтын төв. Л.Жамсрангийн хавтаст хэрэг

2. Ном зохиол:

- 2.1. Борисов О.Б., 1980. *Советско-китайские отношения (1945-1980)*. Москва
- 2.2. Гэндэн Т., 1999. *Гурван түмэн хүний амь.* “Шувуун саарал” ХХК, Улаанбаатар
- 2.3. Лонжид нар., 2020. *Хэлмэгдэл ба цагаатгал: түүх ба баримт.* “Битпресс” ХХК: Улаанбаатар
- 2.4. Лхамсүрэнгийн Бат Очир, 2010. *Догсомын Бодоо.* // Эмхэтгэж, оршил бичиж, хэвлэлд бэлтгэсэн Б.-О. Болд, Б. Туяа, Б. Батболд Улаанбаатар: “Никель Декель» ХХК
- 2.5. Мэндсайхан Х., 2012 *Монгол улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал (1921-1940)*. Улаанбаатар
- 2.6. Отгонбаяр Ё., 2017. *Түүхэн эрхмүүдийн цадиг цуврал: Дашийн Дамба*. НЕПКО: Улаанбаатар
- 2.7. “Монгол Улсын түүх”, 2003. V боть. АДМОН: Улаанбаатар
- 2.8. С.Баатар, 2005. *Эх орончид ба Цэдэнбал.* “Ганпринт” ХХК: Улаанбаатар
- 2.9. China, Soviet Union: Treaty of Friendship and Alliance // *The American Journal of International Law* Vol. 40, No. 2, Supplement: Official Documents (Apr., 1946)
- 2.10. Пятницкая Ю. И., 1987. *Дневник жены большевика*. Benson : Chalidze